




## Нүгэл хааны ноёрхлоос чөлөөлөгдсөн нь

2000 жилийн тэртээ Есүс еврей хүн болж төрөн эрт дээр үед өвөг дээдэст нь амласан Хаант улсын айсууг баталсан сайн мэдээг ард түмэндээ зарласан билээ. Библийн дийлэнх хэсэг еврейчүүдийн тухай бөгөөд тэрхүү үндэстэнд хандан бичигдсэн. Гэтэл бусад үндэстэнд хандсан хэсэг ч Библид байгааг бид өмнөх хэдэн нийтлэлээс харсан! Тухайлбал: Тэнгэр өөд одсоныхоо дараа Есүс Паулыг тусгай элч болгон дуудаж, бүх үндэстэнд зориулсан онцгой нэгэн сайн мэдээг түүнд даатгасан. Энэ сайн мэдээнд Израилд өгсөн амлалт ба Хууль хамаагүй. Хууль дагаж зөвт хүн болохыг зүтгэхийн оронд итгээгч нар Христийн Загалмайн ачаар эхнээс нь зөвт хүнд тооцогдон Ертөнцийн Эзэнтэй эвлэрч Түүнтэй тайван сайхан харилцаатай болдог. Итгээгч бид “хуулийн дор бус, харин нигүүлслийн дор” орсон нь лавтай (Ром 6:15).



“Нигүүлсэл” гэдэг нь Библид “сайн сайхныг хүртэх ёсгүй хүнд үзүүлэх таалал” гэсэн утгатай.

Тэгвэл бид Ертөнцийн Эзэний өмнө цоо шинэ байр суурьтай болсноо мэдэх нь амьдралд маань ямар бодит нөлөө үзүүлэх вэ? Энэ асуултын практик хариу олохын тулд бид энэ нийтлэлд «Ром» 6-р бүлгийг өмнөх хэсэгтэй нь хамт онцгойлон авч үзнэ.




## Улам илүү бялхах хайр ивээл

Ром 3-5-т гардаг, Их Эзэний хэмжээлшгүй хайр ивээлээс урссан Зөвтгөл ба Эвлэрлийн тухай сайн мэдээг хэлж өгөхөд христитгэлтэй олон хүн хариуд нь: *“наад сургаал чинь тун аюултай, хүмүүс хамаагүй гэм хийж болно гэж ойлгоно! Нигүүлсэл бол нүгэл хийхийн шалтаг байж болохгүй”* гэж болгоомжилно. Хэмжээлшгүй хайр ивээлийн сайн мэдээг анх сонссон хүн ийм дүгнэлт гаргаж болох талтай. Паулын үед ч тэгэж ойлгосон хүмүүс байв. **“Хаана нүгэл ихэссэн байна, тэнд нигүүлсэл улам илүү бялхсан юм”** гэж заахад зарим нь хариуд: **“Нигүүлсэл нь ихсэхийн тулд бид нүгэл дотор байсаар байх уу?”** гэж асуусан (Ром 5:20, 6:1).



Паулын дээрх өгүүлбэр Ертөнцийн Эзэний Хуулийг мэддэг хүний хувьд цочирдмоор байхын аргагүй. Хуулийн дагуу “хаана нүгэл ихэссэн байна, тэнд *шийтгэл* улам илүү бялхсан” гэвэл зөв. Хайр ивээл нүглээс илүү бялхах тухай Есүс еврейчүүдэд лав зааж байгаагүй.



Тэнгэрийн хаанчлалыг дүрсэлсэн Түүний ярьсан нэгэн сургаалт үлгэрт зарц нартайгаа тооцоо хийж буй нэгэн хаан, өршөөл гуйсан зарцаа энэрээд



үлэмжийн их өрийг нь хэлтрүүлэхээр болсон. Үүнд тэр зарц өөрт нь өчүүхэн өртэй байсан нөхрөө олж, мөнгөө нэхсэн гэтэл тэр хүн бас л тэвчиж хүлцэхийг гуйсан. Гэвч өөрөө асар их өршөөл хүртсэн сайхь зарц нөхрөө өрөвдөх ч үгүй шоронд хаяв. Ингээд тэр зарц “нүглээ ихэсгэсэн”. Энэ хэргийг сонсоод эзэн нь түүнд лав “нигүүлсэл бялхуулсангүй”, харин ч “өр ширээ бүгдийг нь төлөх хүртэл түүнийг зандалчинд тушаажээ” (Матай 18:23-35).

Тэгэхлээр гэм нүглээс илүү бялхах хайр ивээлийн тухай Паулаар дамжуулсан сургаал нь шив шинэ ойлголтын илчлэл. Өнөөг хүртэл ихэнх хүн энэ сургаалыг сонсоогүй бололтой. Тэд дээрх сургаалт үлгэрийг сайн ойлгодог ч Паулын захидлыг уншсан ч гэсэн утгыг нь нэг л ойлгож авдаггүй. Тэгвэл Паул Хууль ба гэмийн тухай юу гэж бичсэнийг хамтдаа уншиж, Ертөнцийн Эзэний нэг нууцыг мэдэж авъя.

## Хууль өгөгдсөний нууц зорилго

**“Алдаа зөрчил ихэссэн байхын тулд Хууль орж ирсэн. Гэвч хаана нүгэл ихэссэн байна, тэнд нигүүлсэл улам илүү бялхсан юм.**



**Ингэснээр нүгэл нь үхлээр ноёрхсончлон, нигүүлсэл нь бидний Эзэн Есүс Христээр дамжуулан мөнх аминд хүргэх зөвт байдлаар ноёрхох юм.”** (Ром 5:20-21, АБ2004)



Ертөнцийн Эзэн израилчуудад Хууль өгсний гол зорилго нь тэр Хуулийг мөрдүүлэхэд оршоогүй, харин өөр нууц зорилготой байсан. Үүнийг Паул дээрх ишлэлд илчиллээ: Зөрчил гажуудлыг улам их, улам ноцтой болгохын тулд Хуулийг өгсөн гэнэ ээ! Яагаад тэр вэ? Ертөнцийн Эзэний Хуулийг зөрчихөөр хүн Түүний эсрэг тэрсэлж, өөрийгөө дайсан нь болохоо харуулдаг. Харин Их Эзэн нүгэлт хүмүүст ч зогсохгүй, өстөн дайсандаа ч хайр ивээлээ улам илүү бялхуулахыг хүссэн. Энэ бол бараг хэнд ч итгэхэд дэндүү хачирхалтай санаа юм. Энэ үгэнд итгэх хүн лав ховор (АБ2019-г найруулсан хүмүүс үүнд итгэж чадаагүй учраас орчуулгаа өөрчилсөн бололтой).

## **Хоёр хаан ба хоёр хаанчлал нь**

Уг байдлыг бидэнд тайлбарлах гэж Паул дээрх ишлэлд нүгэл ба нигүүлсэл хоёрыг өөрийн хаант улсаа ноёрхдог хаад ноёд мэтээр дүрсэлсэн.<sup>1</sup>

Энэ дэлхийн бүх хүмүүс Нүгэл хааны хаанчлалд төрдөг. Нүгэл хааны хүчийг та юу гэж бодох вэ? Бичвэрийн хариу нь гайхмаар ч гэсэн дээрх нууц зорилготой нийцнэ. Тухайлбал: “Нүгэлийн хүч нь хууль юм” (1 Коринт 15:56)!

Иймд “хууль үгүй бол нүгэл нь үхмэл... тушаал ирснээр нүгэл амилж”-ээ (Ром 7:8-9).

---

1 Хэлний дүрслэх энэ арга хэрэглүүрийг “хүншүүлэл” гэдэг. Хүншүүлэл бол аливаа амьтан, юмс, үзэгдлийг хүнтэй адил ярьж үйлдэх байдлаар дүрслэх арга юм.



Жич: Энэ судалгааны хэмжээнд бид хүншүүлсэн “Нүгэл”, “Нигүүлсэл” хоёрыг нэр болгон томоор бичнэ.

Тэгвэл хуулийн доор буй хүмүүс Нүгэл хааны ноёрхолд хамгийн хүчтэйгээр харьяалагддаг! Зөвхөн Есүс Христээр дамжин хүн Нүгэлийн харьяанаас чөлөөлөгдөн Нигүүлсэлийн хаанчлалд шилждэг юм. Нигүүлсэл хааны дор орсон хүн гэм нүгэл хийсэн ч нигүүлсэл түүн рүү “улам илүү бялхана”.

Энэ сургаалыг анх сонсоод зарим нь *“Бид тэгвэл Их Эзэний хайр ивээлийг өөртөө улам илүү бялхуулаад байхын тулд гэм хийсээр байх нь зөв үү?”* гэж асууна. Ром 6:1-т нэгэн хүн яг тийм ухааны асуулт тавьсан. Энэ асуулт нигүүлслийн тухай Паулын үгийг зөв ойлгосон ч буруу дүгнэлт хийснээс үүснэ. Паулын гайхалтай хариуг зөв ойлгохын тулд бид юуны өмнө нигүүлслийн тухай хэлсэн дээрх үгийг нь сайтар ойлгож авснаа батлах хэрэгтэй.<sup>2</sup> Нигүүлслийн ноёрхол үнэхээрийн бодит юм шүү!

2 Үүний тулд мөн Ром 5-т гардаг Адам ба Христ хоёрын ач холбогдлыг тайлбарласан “Гэм ба үхлийн үйлчлэл” гэдэг судалгааг маань үзнэ үү.



Бид хичнээн муу муухай гэм хийлээ ч гэсэн Ертөнцийн Эзэн тааллаа биднээс татахгүй гэсэн үг! Түүний нигүүлслийн дийлж чадахааргүй гэм үйлдэнэ гэж үнэхээр байхгүй. Гэмийн ачаалал минь хичнээн хүнд байлаа ч Ертөнцийн Эзэний хайр ивээл тэрнээс ч илүүг дааж чадна. Бидэнд өгөгдсөн бялхам их нигүүлсэл, хэмжээлшгүй тэр их хайр ивээл бол хэзээ ч хөдөлшгүй хадан суурь юм.



### **Нигүүлсэл хаан гэм хийлгэхийг хүсдэг гэж үү?**

Тэгвэл бид улам их гэм хийх нь зөв гэж үү? Үүнд Паул шууд л **“Огт үгүй!”** (буюу еврей сэтгэлгээгээр: “Тийм юм хол байг!”) гэж өчөөд, **“Нүглийн хувьд үхсэн бид цаашид яахан түүн дотроо амьдрах билээ?”** хэмээн эргээд асуудаг (Ром 6:2).

Бид амьд яваа хүмүүс байж “нүглийн хувьд үхсэн” гэсэн нь ямар учиртай вэ? Паул үргэлжлүүлэн: **“Христ Есүс рүү баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл рүү баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү?”** (Ром 6:3). Өөрөөр хэлбэл, “өмнөх хэдэн бүлэгт (Ром 3-5) бичсэн сайн мэдээний үндсэн зүйлийг сайн ойлгоогүй юмуу?”



*“Харин тийм ээ, Паул ахаа, таны бичсэн захидлыг ойлгоход тийм ч амар биш. Ялангуяа таны үг Есүс ба бусад апостолын үгтэй зөрчилдөх үед, дээр нь сүмд ер нь энэ сайн мэдээг заадаггүй учраас тун хэцүү шүү...”* гэж танд бас хэлмээр санагдсан уу?

“Бичвэрийг  
Бичвээрээр  
тайлдаг”

## **Бид “Христ Есүс рүү баптисм хүртсэн”-ий учир**

*“Бичвэрийг Бичвээрээр тайлдаг”* гэсэн чухал зарчмыг дагая. Тэгвэл, “Христ Есүс рүү баптисм хүртэх” гэсэн дээрх ишлэлийн хэллэгийг мөн ашигласан ишлэлийг үзэхээр энэ нь Христийг “өмсөж”, Түүний Биеийн гишүүн болж Сүнсийг нь “уусан” болохыг хэлнэ (Галат 3:27; 1 Коринт 12:13). Өөрөөр хэлбэл бид одоо “Түүнтэй нэг сүнс болой” (1 Коринт 6:17)

Хүн зан үйлээр “Христ дотор” орох боломжгүй нь ойлгомжтой. Тэгэхлээр энэ баптисм усан баптисм биш, харин “сүнсэн баптисм” юм. Энэ баптисм нь үхээд оршуулагдан эргээд амилсан Христтэй нэгдсэний дүрслэл юмуу бэлэг тэмдэг учраас үүнд нэг ч дусал ус ордоггүй (Колоссай 2:12). Тэрхүү сүнсэн баптисмаар бид Христтэй амин сүнслэг холбоосоор холбогдсон. Толгой нь үхэхээр бие нь ч хамт үхдэг нь жам. Тиймээс ч бид Түүнтэй хамт “нүглийн хувьд үхсэн” (Ром 6:2).






Үүнчлэн бид мөн Тэргүүнийхээ хамт үхэгсдээс амилсанд тооцогддог. Христ үхлээс амилах амилалд манлайлсан бөгөөд бид зайлшгүй Тэргүүнийхээ араас дагах учиртай. Тийм явдал болсныг бид амьдралаасаа хараагүй, дотроо мэдрэхгүй ч гэсэн Ертөнцийн Эзэн “Христ доторх” биднийг тэр л байдлаар хардгаа бидэнд мэдүүлэх гэж Паулаар бичүүлсэн. Тэгэхлээр Христэд итгэх гэдэг нь Түүний үхэл ба амиллыг хуваалцсандаа итгэхийг ч багтаана. Нүглийн хувьд үхээд нигүүлсэл дүүрэн цоо шинэ амьдралтай болсондоо итгэдэг хүн гэм нүгэл хийх сонирхолтой гэж үү? Үгүй, харин шинэ амийн дотор явахыг хүснэ.

**“Бид үхэл уруу баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм. Хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж Түүний амилалтай нь ч адил байдалд бас холбогдох болно”**  
(Ром 6:4-5).



“Холбогдсон” гэж орчуулсан грек үг (G4854) “хамт суулгагдсан” юмуу “хамт ургасан” гэсэн утгатай. Есүс Өөрийгөө “газар унаж үхэх” үртэй зүйрлэжээ (Иохан 12:23-24). Бид Түүнтэй хамт “газар унаад үхсэн”-д



тооцогддог. Тэгээд нийлж ургасан ганц сайхан ургамал газраас урган гарах мэт Түүнтэй нэгдсэн бид үхэгсдээс хамт амилж шинэ бүтээл болсонд мөн тооцогддог.

## Шинэ бүтээл нүгэлтэн биш

*“Наад сургаал чинь хамаагүй гэм хийхэд хүргэнэ”* гэсэн бодол хуулийн доор амьдарч буй хүний сэтгэлгээнээс төрдөг. Хууль дүрэм дагаж, гэм хийхгүй байхыг хичээдэг хүн Ертөнцийн Эзэний хэмжээлшгүй хайр ивээлийн тухай сайн мэдээг “гэм хийх шалтаг” гэж эсэргүүцнэ. Хэрэв бид өөрсдийгөө “нүгэлтэн” хэвээр гэж үзвэл энэ нь бидний хэн болохыг тодорхойлно.

Хонь майлдаг, адуу янзгаадаг, харин нүгэлтэн нүгэл үйлддэг. Ертөнцийн Эзэний Хуулийн доор орох нь харин нүгэлтний мөн чанарыг өөрчлөхгүй!

Харин ч эсрэгээр нь хууль нь нүглийг улам ихэсгэж, ил гарган “туйлын нүгэл” болоход хүргэдэг (Ром 5:20, 7:7-13).

Иймд “хууль үгүй бол нүгэл нь үхмэл... тушаал ирснээр нүгэл амилж”-ээ (Ром 7:8-9). Үүнийг бид амьдралаас ч мэддэг.

Ямарваа зүйлийг хүүхэддээ “болохгүй шүү!” гэж анхааруулвал сэтгэл нь нэг мэдсэн чинь яг тэр зүйлд татагдаж эхэлдгийг эцэг эхчүүд сайн мэднэ байх.

“Нүглийн хүч нь хууль” учраас тэр (1 Коринт 15:56).





“Бид нүгэлдээ байсаар байх уу?” гэсэн асуултад Паул яагаад “огт үгүй!” гэж хариулсан гэвэл нэгэнт “нүглийн хувьд үхсэн” биднийг Ертөнцийн Эзэн нүгэлтэн гэж тооцохоо больсон учраас тэр. Тэрээр биднийг одоо ч “Христ дотор” буй Христийн, үхлийн чанадах амьдралыг хуваалцдаг ариун гишүүнд нь тооцдог. Бидний хэн болох нь бусдын бодсоноос хамаарахгүй, өөрийн минь үйлсээс ч, өөрийгөө дүгнэх дүгнэлтээс минь ч шалтгаалахгүй. Биднийг бүтээсэн Эзэн л бидний хэн болохыг тодорхойлох эрхтэй. Зөвхөн Бүтээгч Эзэн маань бидний хувь заяаг мэднэ. Бидний хэн болохыг өнгөрсөн амьдрал минь биш харин Түүний урьдаас хэлсэн ирээдүй минь харуулна. Нэгэнт гэм нүгэл бидний ард үлдсэн байхад бид яах гэж “гэм дотор” хутгалдсаар байх вэ?!

## Нүгэл хааны хаанчлалаас гарах ганц арга зам

**“Бидний нүглийн биеийг хүчингүй болгохын тулд хуучин хүн маань Түүнтэй хамт цовдлогдсон гэдгийг бид мэддэг”** байх нь дэндүү чухал (Ром 6:6).

Тайлбарлаваас, “хуучин хүн маань” Адамаас гаралтай хүний байгаа байдлыг хэлнэ.

Адамын зөрчлийн улмаас хүн “нүгэлтэн болгогдсон” бөгөөд Нүгэл хааны боолчлолд “худалдагдсан” (Rom 5:19, 7:14).





Ингээд Нүгэл хаан хүн төрөлхтөнийг үхэн үхтэл нь захирдаг болсон (Ром 5:12-21).

*Жич: Паулын бичсэн захидалд ганц тоот “Нүгэл” нь хүний хийдэг буруу үйлийг биш, харин махбодод маань оршин, тэр буруу үйлсийг өдөөдөг хүчийг хэлдэг юм.*

*Библид Паулаас өөр хэн ч*


*далд орших тэрхүү хүчийн тухай бичээгүй.*

*Монгол орчуулганд ганц тоо, олон тоо тэр болгон харагддаггүй нь монгол хэлний онцлогтой холбоотой.*


Улмаар, гэм нүгэл бидний дотор буюу махбодод минь оршин байдаг болсон (Ром 7:14-20). Өөрөөр хэлбэл, “нүглийн бие” маань Нүгэл хааны хаант улсыг бүрдүүлнэ. Ямар ч засвар, шинэчлэл хийх нь Нүгэл хааныг хөөж дийлэхгүй. “Нүглийн бие”-д маань ямар ч найдвар байхгүй гэсэн үг. Хүн үхэх замаар л Нүгэлийн ноёрхолоос гарна. Өөр арга алга.

Христийн Биеийнхэн “Христтэй хамт цовдлогдсон”-оо МЭДЭХ нь чухал. Энэ бол бидний мэдээд зогсохгүй, учрыг нь сайтар ойлгох ёстой Бичвэрүүдийн танин мэдэхүй юм.

Хуучин хүн маань “Христ Есүстэй” “хамт цовдлогдсон” (G4957) гэдэг нь яг юуг хэлдэг вэ? Энэ нь Түүний хамт загалмай дээр буюу гутамшгийн гадсан дээр цаазаар авахуулсан байхыг хэлнэ. Ертөнцийн Эзэний хувьд “хуучин хүн” маань Есүстэй “хамт цовдлогдсон” хоёр гэмт хэрэгтнээс дээргүй учраас тэр (Иохан 19:32, G4957). Хамгийн сайн хүмүүс хүртэл Нүгэл хааны боолчлолд төрж тэр хаандаа үйлчилдэг учраас тэр.



Гэхдээ Ертөнцийн  
Эзэний авсан арга  
хэмжээ тэр  
боолчлолыг устган  
биднийг гэм ба  
үхлээс аварна (Ром  
8:2). Тэр авралыг  
бүтээх гэж  
Ертөнцийн Эзэний  
Хүү Өөрийн биеэрээ  
үхээд амилах



шаардлагатай байв. Бүх юм “Бүтээлийн Ууган” болох  
“Түүн дотор бүтээгдсэн” учраас тэр (Колоссай 1:16).  
Есүсийг үхэхэд “Түүн дотор бүтээгдсэн” хүн төрөлхтөн  
тэрхүү дотоод холбоосны улмаас хамт үхсэнд  
тооцогддог. “Нэг нь бүгдийн төлөө үхсэн тул бүгд  
үхсэн” нь тийм учиртай (2 Коринт 5:14). Тэгвэл Нүгэл  
хааны ноёрхол Загалмай дээр албан ёсоор эцэс  
болсон юм. Нүгэл хааны сүйрэл Загалмайн дээр  
зарлагдсан бөгөөд цаг нь ирэхэд биелэх нь зайлшгүй.

Үүгээр ч зогсохгүй, Есүс Христ үхлээс амилсан нь  
шинэ бүтээлийн эхлэл болжээ. Паулын бичсэнчлэн,  
Есүс Христ “үхэгдсийн амиллын Ууган” нь болсон  
(Колоссай 1:18). Хүн төрөлхтөн анх “Түүн дотор  
бүтээгдсэн” шигээ өнөө дотоод холбоосны ачаар бас  
үхлээс амилсан Түүн дотор шинээр бүтээгдсэн байна  
(Эфэс 4:24).

Үүний дүрслэлээр самар дотор нуугдаж буй хуш модыг  
бодоорой. Дан самрыг харахад дотор нь тийм мод  
байгааг төсөөлөхийн аргагүй. Харин цаг нь болоход



самар соёолж хуш мод нь гарч ирэн өндөр сайхан мод болж ургана. Үүнчлэн шинэ хүн төрөлхтөн одоо ч Христ дотор нуугдсан байна.



### **Нүглийн бие маань Загалмайд хүчингүй болсон**

Өнөөдрийн байдлаар амьд яваа хүмүүс бүгд “нүглийн бие”-тэй хэвээрээ. Үхэх тавилантай бие махбодод маань нүглийн хүч нэгэнт оршдог учраас бид бүгд, Христэд итгэдэг, итгэдэггүй нь хамаагүй, гэм нүгэл хийдэг. Гэм хийдэггүй хүн нэг ч байхгүй (Ром 3:23). Христэд итгэгч хүмүүс тэгвэл юугаар ялгаатай вэ? Ертөнцийн Эзэн биднийг одоо ч сүнсний хувьд Нүгэл хааны ноёрхлоос гаргаж, Нигүүлсэл хааны ноёрхлын доор оруулсан (Ром 5:21).

“Хуучин хүн маань” Христтэй “хамт цовдлогдсон”-ы үр дүнд “нүглийн бие” маань “хүчингүй” болсныг бид ухаарч, итгэлээр хүлээж авах ёстой (Ром 6:6).

“Нүглийн бие” маань биднийг гэм нүгэл хийхэд хүргэсэн ч тэр нь Ертөнцийн Эзэний хувьд “хүчингүй” гэсэн үг. “Нигүүлсэл хаан”-ы ноёрхол ямар ч гэмийг бялхан авч, дийлнэ. Энэ бол шударга ёсыг хангасан Загалмайн үндсэн дээр ажиллах Ертөнцийн Эзэний хайр ивээлийн хүч чадал юм!

Үүнийг анх сонсоход итгэмээргүй юм шиг санагдаж магадгүй. Тэгвэл Паулын бичсэн дараагийн үгсийг уншиж үнэхээр тийм утгаар бичсэнийг харах болно.



**“Тиймээс хойшид бид нүгэлд боолчлуулахгүй. Учир нь үхсэн хүн нүглээс чөлөөлөгдсөн [грек: зөвтгөгдсөн, цагаатгагдсан] байдаг юм”** (Ром 6:6-7). Үхлээр дамжин “нүглээс чөлөөлөгдсөн” юмуу “зөвтгөгдсөн” нэгний хамгийн чухал жишээ бол Есүс Христ. Их Эзэн маань Өөрөө хэзээ ч гэм хийгээгүй ч гэсэн өнөө дотоод холбоосны улмаас ертөнцийн гэм нүглийг үүрдэг байсан (Иохан 1:29). Энэ дэлхийд төрсөн мөчөөсөө эхлэн Есүс тэр хар бараан үүлийн дор амьдарчээ. Загалмай дээр үхэхдээ харин тэр ачаанаас үүрд мөнхөд салж, ингээд Нүгэл хаантай ямар ч холбоогүй болжээ. Тэрээр “нүглийн хувьд нэгмөсөн үхсэн” (Ром 6:10).



Тэгвэл Түүнтэй нэгдсэн бид Ертөнцийн Эзэний тооцоноор Түүнтэй хамт үхсэн учраас мөн адил “нүглийн хувьд үхсэн” (Ром 6:2), өөрөөр хэлбэл Нүгэл хааны дарлалаас чөлөөлөгдсөн бөгөөд цаашид тэр хаанд үйлчлэх албагүй. Энэ яг юу гэсэн үг вэ? Итгэгч болоод цаашид хэзээ ч дахин гэм хийхгүйг хэлээгүйг бид амьдралаасаа сайн мэднэ. Одоохондоо бид сул дорой, үхэж буй “нүглийн бие”-тэй хэвээрээ гэдгийг дахин сануулъя (Ром 6:6,19). Харин Есүс Христ биднийг нэг ёсондоо Өөрийн үхэл ба амилалдаа авч явсан учраас нүглийн бие маань Түүн шиг үхсэнд тооцогдоно. Тийм учраас энэ биеэр амьд явах үлдсэн хугацаандаа бидний хийх бүх гэм Ертөнцийн Эзэний өмнө хүчингүйд тооцогддог.



Өөрөөр хэлбэл, бид өнгөрсөнд хийсэн, ирээдүйд ч хийх бүх гэм нүглээсээ одоо ч цагаатгагдсан. 2000 жилийн тэртээд та бидний бүх гэм ирээдүйд л оршин байсан шүү дээ. Ийн зөвтгөгдсөн хүн бол буруутгахааргүй болсон, өөрөөр хэлбэл “нүглээс чөлөөлөгдсөн”. Нүгэлийн нөлөө, Нүгэлийн хүч чадал,



Нүгэлийн буруутгал бидэнд хамаагүй болсон гэсэн үг. Үхсэн нэгнийг буруутгаж болдог уу? Үхсэн хүнийг шийтгэж

болдог уу? Болохгүй. “Нүглийн хувьд үхсэн”-д тооцдог хүнээ Ертөнцийн Эзэн гэм нүгэл хийсэнд тооцдоггүй юм. Одоогийн махбодийнхоо сул доройгоос болж гэм нүгэл хийлээ ч гэсэн бид Нигүүлсэл хааны хаанчлалын доор орсноос хойш Христ дотор зөвтгөгдсөн хүний байр сууриа алдахгүй. Ертөнцийн Эзэний үгэнд бат итгэсэн итгэгч муу ёрын сүнсний тулгах буруутгалыг шууд няцаах бүрэн эрхтэй юм шүү.

*Жич: энэ сургаал Ертөнцийн Эзэний өмнөх байр суурийг авч үздэг болохоос янз бүрийн буруу юм хийвэл нийгмийн амсуулах үр дагаврыг хэлээгүй нь мэдээж гэж анхааруулах шаардлагагүй буй за!*



Нөгөө талаар Нүгэл хааны хувьд үхсэн хүн өөрөө нүгэл хийхийн тухай боддог уу? Үгүй, Нүгэлийг цааш анхааран боддоггүй, болгоомжлон тоодог ч үгүй!

“Гэхдээ би яг хэлэхэд үхээгүй шдээ!” гэж та гайхаад л байж магад.

Харин тийм ээ, тийм ч учраас энэ сургаал итгэлийн үнэн хувьсгал юм! Бид “харснаараа биш итгэлээр алхах”-ад дуудагдсан нь бас тийм учиртай (2 Коринт 5:7).



## Бид шинэ эзэнтэй, шинэ амьдралтай

Паулын үгийг цааш уншихад:

**“Хэрэв бид Христтэй хамт үхсэн бол мөн Түүнтэй хамт амьдрах болно гэдэгтээ итгэдэг. Түүнчлэн Христ үхэгсдээс амилуулагдсан тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ. Үхэл цаашид Түүнийг захирахгүй. Учир нь Тэрээр үхэхдээ нүглийн хувьд нэгмөсөн үхсэн бөгөөд харин Түүний амьдардаг амьдралын хувьд, Тэрээр Бурханд амьдардаг юм.”** (Ром 6:8-10)

Христийн амилал бол хосгүй. Найн хотын залуу, Иаирын охин, Лазар зэрэг хүмүүс үхлээс амилсан ч хожим дахин үхсэн. Тэдний амилал бол уруудан өнгөрөх өмнөх амьдралдаа эргэж ирсэн явдал байв.



Тэд Нүгэл хааны хаанчлалд эргэн ирсэн.

Харин Христийн амилал үндсээрээ өөр төрлийнх.

Тэрээр үхлийг нэгмөсөн ардаа орхисон бөгөөд хэзээ ч дахин үхэхгүй. “Бидний Аврагч Христ Есүс... үхлийг

хүчингүй болгож, амь ба мөхөшгүй байдлыг сайн мэдээгээр гэрэлд авчирсан” (2 Тимот 1:10).

Нүгэл ба үхлийг ардаа үлдээсэн, муудан өнгөршгүй яруу жавхланта тэр амьдралыг Есүс Христ хамаг бүтээлийн төлөө эхлүүлснээ сайн мэдээгээр бидэнд мэдүүлсэн. Тэрний хажууд бидний өнөөгийн амьдрал удааширсан үхлээс өөр юу ч биш юм. Христийн авчирсан амьдрал бол жинхэнэ АМЬ. Тэр амьдрал Бүтээгч Эзэнд зориулсан бөгөөд Түүний дэргэд явагдана. Яг тэр амьдралын урьдчилгаа Христийн Биеийн гишүүдэд өнөөдөр ч сүнсээр өгөгдсөн. Үүнийг яаж хүлээж авах вэ гэвэл:

**“Яг түүнчлэн та нар өөрсдийгөө нүглийн хувьд үхсэн бөгөөд Бурханы хувьд Христ Есүсээр амьд байгаа гэж тооц”** гэсэн

маш чухал энэ бодит зөвлөгөөг сайн анхаараарай (Ром 6:11). Бидний хийх ёстой бодит зүйл бол Ертөнцийн Эзэний зааж өгсөний дагуу зөв тооцоо хийхэд орших юм!





“Тооцох” гэдэг нь “нүглийн хувьд үхсэн юм шиг өөрөө өөртөө санагдах” зэрэг сэтгэлийн хөдөлгөөнийг гээгүй, тэрний шинж тэмдгийг амьдралаасаа хайж олохыг ч хэлээгүй – харин өөрийн чинь тухай Ертөнцийн Эзэний бичүүлсэн үгийг хүлээн авч, өөрийгөө харах хараандаа шингээн оруулж, өдөр бүрийн амьдралдаа тэр үнэний дагуу итгэлтэй амьдарч явахыг хэлнэ.

Тэгэхлээр Их Эзэн биднийг бодлоо өөрчлөөсэй гэж хүсдэг юм. Тэрээр биднийг ирээдүйд ямар байх тэр л байдлаар өнөөдөр ч харж, харьцдаг учраас бид ч гэсэн өөрсдийгөө Түүн шиг харж сурвал зохино. Христтэй нэгдсэний ачаар бид шинэ эзэнтэй болж, Нүгэл гэдэг боолын эзэнтэй ямар ч холбоогүй болсон. Үүний дагуу Нүгэлд хандах хандлагаа ч өөрчлөхийг Их Эзэн биднээс хүсдэг.

### **Бид Нүглийг үл тоон, эсрэг нь тэмцэх ч үгүй**

Тийм ээ, энэ сургаал “бид нүглийн эсрэг тэмцэх ёстой” гэсэн түгээмэл сургаалыг үгүйсгэдэг. Гэтэл Нүгэлийн эсрэг тэмцдэг хүн Нүгэл хааныхаа эсрэг бослого явуулж байгаа мэт. Тэр хүн Нүгэлийн хаанчлалаас гараагүй нь ил. Аль болохоор гэм нүгэл





хийхгүй байхыг хичээснээрээ Нүгэлтэй харин ч байнгын зууралдаастай байна. Тийм хүн өөр хэнээс ч илүүтэйгээр Нүгэлийн боолчлолд автагдана. “Амийг амласан [хуулийн] тушаал нь үхэлд хүргэдэг... учир нь тушаалаар шалтаглаж Нүгэл намайг мэхэлсэн...” гэдгийг Нүгэлийн эсрэг тэмцэгч бүгд аяндаа ухаарна (Ром 7:10-11).

Харин нэгмөсөн зөвтгөгдсөнөө мэдэж авсан хүнийг тэр л үнэн чөлөөлнө. “Шинэ амийн дотор алхдаг” хүн Нүгэлийн хаанчлалаас гарсан учраас Нүгэлийг тоох ч хэрэг байхгүй. Ертөнцийн Эзэн биднийг нэгэнт Нүглийн хувьд үхсэнд тооцдог бол бид яах гэж нүглийн эсрэг тэмцэх ёстой гэж?



Нүглийг бодохын оронд бид анхаарлаа шинэ Эзэн дээрээ тогтоох нь зөв. Түүний хэлсэнд итгэж, өөрийгөө зөвтгөгдсөн хүн гэж харж, энэ үнэнтэй хөл нийлүүлэн алхдаг хүн өөрийн



эрхгүй хайрт Аврагчдаа талархаж, Түүний адил Ер бусын Эцэгтээ зориулж амьдарна. Бидний дотор оршдог ариун Сүнс зөв амьдрах хүслийг ч, хүч чадлыг ч хайрладаг. Амиллын амьдралаар бид одоо ч амьдрахад дуудагдсан учраас тэр. □

*Дараагийн нийтлэлд бид Нигүүлсэл хааны туйлын ноёрхлыг авч үзэнгээ «Ром» захидлын 6-р бүлгийг үргэлжлүүлэн судлах болно.*

#### Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)